



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/619

Булган сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний  
хугацаа сунгах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны IX/19 дүгээр тогтоолоор баталсан “Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй эзэмшиж буй газрын зориулалт нь нийцэж байгаа хавсралтад заасан 3 иргэний 3 нэгж талбарын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 15 жилээр сунгасугай.

2. Хавсралтад заасан 3 иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг энэхүү захирамжийн хавсралтад тусгасан 3 иргэнд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2024 оны  
09 дүгээр сарын 11-ний өдрийн А/619 дугаар  
захиралтын хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУГАЦАА СУНГАЖ БАЙГАА  
ИРГЭДИЙН НЭРС, ГАЗРЫН ХЭМЖЭЭ, БАЙРШИЛ

№	Иргэний овог нэр	Регистрын дугаар	Газрын зориулалт	Баг	Гудамж	Хаалганы дугаар	Газрын хэмжээ м2	Нэгж талбарын дугаар
1	Төвжэнхар	ЦГ66111306	Амины орон сууц	6	Залуус-14	1408	784	6308002822
2	Дамдинжамц	ГА81112973	Орон сууц	5	Л.Энэбиш-2	225	1049	6308003742
3	Доржготов	ГЮ65101410	Орон сууц	5	Л.Энэбиш-2	209	2031	6308003647